



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх журам”-ыг 1 дүгээр, “Дуудлага худалдаанд оролцох хүсэлт”-ийн загварыг 2 дугаар, “Дуудлага худалдаанд оролцогчийн эрх, үүрэг”-ийн маягтыг 3 дугаар, “Дуудлага худалдаа явуулах тушаал”-ын загварыг 4 дүгээр, “Дуудлага худалдааны зар”-ын загварыг 5 дугаар, “Дуудлага худалдааны мэдэгдэл”-ийн загварыг 6 дугаар, “Дуудлага худалдааны тэмдэглэл”-ийн загварыг 7 дугаар, “Хоёр дахь дуудлага худалдааны тушаал”-ын загварыг 8 дугаар, “Үнийн санал авах хуудас”-ын загварыг 9 дүгээр, “Эрх шилжүүлэх гэрээ”-ний загварыг 10 дугаар, “Худалдах, худалдан авах гэрээ”-ний загварыг 11 дүгээр, “Хуваарилалтын тооцооны акт”-ын загварыг 12 дугаар, “Худалдан борлогдоогүй эд хөрөнгийг татвар төлөгчид буцаах тухай” загварыг 13 дугаар, “Дуудлага худалдааны дэнчинг улсын орлого болгох тухай” загварыг 14 дүгээр, “Авлагын хүсэлт”-ийн загварыг 15 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журам, маягтыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг Татварын хэлтэс /газар/-ийн дарга нарт, энэ талаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Д.Ганбат/, Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан ҮТЕГ-ын даргын 2008 оны 220 дугаар тушаалын 2 дугаар хавсралт, ТЕГ-ын даргын 2014 оны А/26 дугаар тушаалыг хүчингүй болгох арга хэмжээ авахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ БОЛОН ШУУД ГЭРЭЭГЭЭР МӨНГӨН ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Татварын ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.2-т заасан татварын албаны битүүмжилсэн хөрөнгө, барьцааны зүйлээс Иргэний хуулийн холбогдох заалт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаа зохион байгуулж, эсхүл шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Өртэй татвар төлөгчийн битүүмжилсэн хөрөнгө, барьцааны зүйлийг дуудлага худалдаа болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг тухайн татвар төлөгч /тухайн хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч/-ийн шууд харьяалах татварын алба /цаашид “татварын алба” гэх/ зохион байгуулна.

1.3.Дуудлага худалдааг явуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийг баримтална.

1.4.Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.12-т заасны дагуу Дуудлага худалдаа зохион байгуулахтай холбоотой мэдээллийг татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд тухай бүр бүртгэнэ.

1.5.Татварын алба дуудлага худалдаа зохион байгуулах зардал болон дэнчин байршуулах төрийн сангийн данстай байна.

1.6.Дуудлага худалдаа явуулахтай холбогдсон энэ журмаар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Газрын тухай хуульд заасны дагуу зохицуулна.

1.7.Эрх зүйн маргаантай хөрөнгийг дуудлага худалдаанд оруулах, шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэхийг хориглоно.

Хоёр.Хөрөнгө худалдан борлуулах дуудлага худалдааны төрөл

2.1.Дуудлага худалдааг дараах төрлөөр зохион байгуулна:

2.1.1. албадан дуудлага худалдаа /цаашид дуудлага худалдаа гэх/;

2.1.2. үнэ хаялцуулах дуудлага худалдаа;

2.2.Өртэй татвар төлөгчийн үл хөдлөх эд хөрөнгө, үнэт цаас, түүх соёлын өвд хамаарах үнэт зүйлс, тусгай зөвшөөрөл зэргийг энэ журмын 2.1.1-д заасны дагуу хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдан борлуулна.

2.3.Өртэй татвар төлөгчийн хөдлөх хөрөнгийг энэ журмын 2.1.2-т заасны дагуу үнэ хаялцуулах дуудлага худалдааг худалдан борлуулна.

2.4.Үнэ хаялцуулах дуудлага худалдааг энэ журам болон Иргэний хуулийн 197 дугаар зүйлд заасны дагуу явуулна. Сангийн яамтай зөвших

2.5.Татвар ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.5-д заасан нөхцөлд тухайн хөрөнгийг шууд гэрээгээр мөнгөн хөрөнгөд шилжүүлнэ.

Гурав.Дуудлага худалдааг зохион байгуулах

3.1. Дуудлага худалдааг Том татвар төлөгчтэй харилцах нэгж нь өөрт харьяалагдах татвар төлөгчийн, нутаг дэвсгэрийн зарчмаар Аймгийн татварын газар, хэлтэс, Нийслэлийн татварын газар нь нийслэлийн хэмжээнд тус тус зохион байгуулна.

3.2. Үнэт цаасны дуудлага худалдааг тухайн үнэт цаасны төлбөр, тооцоо, бүртгэл хариуцсан байгууллагаар гүйцэтгүүлнэ.

3.3. Энэ журмын 3.1-д заасан тухайн татварын албаны дарга дуудлага худалдааг зохион байгуулах ажлын хэсэг, дуудлага худалдаа эрхлэн хөтлөгчийг томилно

Дөрөв.Хөрөнгийн дуудлага худалдааны үнэ тогтоох

4.1.Ажлын хэсэг нь хөрөнгийн дуудлага худалдааны үнийг тогтоохдоо Татварын ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.3-т заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 55 дугаар зүйлд заасныг баримтална.

4.2.Анхны болон хоёр дахь дуудлага худалдааны үнийг Иргэний хуулийн 177 дугаар зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3-т заасны дагуу тогтооно.

4.3.Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/-ийг дуудлага худалдаагаар худалдан борлуулахдаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3-т заасныг баримтална.

Тав.Хөрөнгийн дуудлага худалдаа явуулах шийдвэр

5.1.Дуудлага худалдаа явуулах хугацааг товлосон шийдвэрт дараах мэдээллийг тусгана:

5.1.1.Үл хөдлөх эд хөрөнгийн нэр, хэмжээ, зориулалт, байршил, анхны үнэ, өмчлөгчийн тухай;

5.1.2.Дуудлага худалдааг явуулах он, сар, өдөр, цаг, хаяг;

5.1.3.Уг дуудлага худалдаа нь албадан дуудлага худалдаа гэсэн тодотгол;

5.1.4.Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн дугаар;

5.2.Татварын алба нь энэ журмын 2.1-д заасан ажлын хэсэгт дараах бичиг баримтыг хүргүүлнэ:

5.2.1.хөрөнгө битүүмжилсэн тухай битүүмжлэх акт, битүүмжлэлийн хуудас, битүүмжлэх мэдэгдэх хуудас;

5.2.2.хөрөнгө барьцаалсан тухай барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ;

5.2.3.хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт, улсын бүртгэлийн холбогдох бичиг баримтын хуулбар;

5.2.4.тухайн хөрөнгийн ашиглах, эзэмших гэрчилгээний хуулбар;

5.2.5.үл хөдлөх эд хөрөнгө байрлаж байгаа газрыг ашиглах, эзэмших, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн бичиг баримт.

5.3.Дуусаагүй барилга байшин, дэд бүтцийн объектийг албадан дуудлага худалдаагаар борлуулах бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т зааснаас гадна тухайн барилга байшин, дэд бүтцийн объектийг барих тусгай зөвшөөрлийн хуулбарыг дуудлага худалдааг эрхлэн хөтлөх этгээдэд хүргүүлнэ.

5.4.Ажлын хэсэг нь энэ журмын 5.2-д заасан бичиг баримтыг хүлээн авч дуудлага худалдаа зохион байгуулах шийдвэр гаргана. Шийдвэрийг бүртгэх байгууллага болон өртэй татвар төлөгчид хүргүүлнэ.

Зургаа. Дуудлага худалдааг хойшлуулах, түдгэлзүүлэх

6.1.Татвар төлөгч өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах санал гаргасан тохиолдолд 3 сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно. /ШШГГ-ын хүнээс асуух 67 дугаар зүйлийг/

6.2.Журмын 6.1-д зааснаас бусад хөрөнгийн анхны үнэлгээг тогтоосноос хойш татвар төлөгч өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах санал гаргасан тохиолдолд 2 сар хүртэл хугацаагаар хойшлуулж болно. /ШШГГ-ын хүнээс асуух 67 дугаар зүйлийг/

6.3.Дуудлага худалдааг дараах үндэслэл, хугацаагаар түдгэлзүүлнэ:

6.3.1. хөрөнгийн анхны үнэлгээний талаар шүүхэд гомдол гаргасан бол шүүхийн эцсийн шийдвэр гарч, хүчин төгөлдөр болтол;

6.3.2. татвар төлөгч иргэн нас барсанд тооцсон, сураггүй алга болсон, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бол тэдгээрийн эрх, үүрэг эрх залгамжлагчид шилжих, эсхүл сураггүй алга болсонд тооцогдсон иргэний эд хөрөнгийг эрхлэн хамгаалагчийг, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй иргэнд асран хамгаалагчийг тогтоох хүртэл;

6.3.3. татвар төлөгч иргэн, эсхүл хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, төлөөлөгчийг эрэн сурвалжилж, олж тогтоох хүртэл.

Долоо. Дуудлага худалдаа явуулах хугацаа

7.1. Дуудлага худалдааг ажлын хэсгийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор явуулна.

7.2. Хөрөнгийн үнэлгээ тогтоосноос хойш 2 сарын дотор худалдан борлуулна.

7.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1-д заасны дагуу татвар төлөгч өөрийн хөрөнгийг бие даан худалдан борлуулах тухай саналыг хүлээн авсан тохиолдолд 3 сарын дотор албадан худалдан борлуулах ажиллагааг явуулна.

Найм. Дуудлага худалдааг нийтэд мэдээлэх, дуудлага худалдааны оролцогч, дуудлага худалдаанд оролцох дэнчин

8.1. Дуудлага худалдаа явуулах хэлбэрээс хамаарч дуудлага худалдааг эрхлэн хөтлөгч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, Иргэний хуулийн 197.13-т заасан хугацаанд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр энэ тухай нийтэд мэдээлнэ.

8.2. Дуудлага худалдаанд оролцохоор дэнчин төлж бүртгүүлсэн этгээд, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцоно.

8.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.3-т заасан дуудлага худалдаанд зөвхөн Монгол Улсын иргэн оролцоно.

8.4. Дуудлага худалдаанд дараах этгээд шууд болон шууд бус байдлаар оролцохыг хориглоно:

8.4.1. хөрөнгийг өмчлөгч, эзэмшигч татвар төлөгч этгээд;

8.4.2. татварын албаны татварын улсын байцаагч, ажилтан, албан хаагч;

8.5. Анхны болон хоёр дахь дуудлага худалдаанд оролцогч нь тогтоосон үнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний дэнчинг төлнө.

8.6. Дэнчинг татварын албаны төрийн сангийн дансанд байршуулна.

8.7. Дуудлага худалдаанд оролцогч нь дуудлага худалдаанд ялагч болоогүй тохиолдолд урьдчилан төлсөн дэнчинг эргүүлэн олгоно.

Ес. Дуудлага худалдааг зохион байгуулах

9.1. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр, төлбөрийн хэмжээ, үл хөдлөх эд хөрөнгийн талаар танилцуулга, түүнийг битүүмжилсэн, барьцаалсан он, сар, өдөр, үнийг танилцуулна.

9.2. Анхны үнийн санал гарснаар дуудлага худалдааг эхэлсэнд тооцно.

9.3. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь хөрөнгийн үнийг өсгөн дуудах үнийг доод хэмжээг тогтоож тэмдэглэл үйлдэнэ.

9.4. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь сүүлийн үнэ хэлэхийг зарлаж 3 удаа дуудсаны дараа дуудлага худалдааг дуусгавар болгож ялагчийг зарлана.

9.5. Үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдааг зогсоох, түр хойшлуулах, хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулахдаа Иргэний хуулийн 176, 177 дугаар зүйлийг баримтална.

9.6. Дуудлага худалдаагаар борлогдсон үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.10-т заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

9.7. Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг нь дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор ялагчийн нэр, овог, нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан эд хөрөнгийн үнэ, хөрөнгийн үнийг бүрэн төлсөн болон, өмчлөх эрх үүсэх, өртэй татвар төлөгч эд хөрөнгө чөлөөлөх хугацааг заасан шийдвэр гаргана.

9.8. Дуудлага худалдаагаар борлогдоогүй Монгол Улсын иргэнд өмчлүүлсэн газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн дуудлага худалдаа явуулахад гарсан зардлыг төсвөөс санхүүжүүлнэ. Сангийн яамтай зөвшилцөх,

Арав.Дуудлага худалдааны ялагчтай гэрээ байгуулах, хөрөнгийн эрх шилжүүлэх

10.1. Дуудлага худалдааны явцад тэмдэглэл үйлдэх бөгөөд уг тэмдэглэлд оролцогчид болон ажлын хэсгийн дарга гарын үсэг зурснаар дуудлага худалдааг хүчин төгөлдөр явагдсанд тооцно.

10.2. Дуудлага худалдааны ялагч нь тэмдэглэл болон гэрээнд гарын үсэг зурахаас зайлсхийсэн тохиолдолд дэнчингээ алдана.

10.3. Ажлын хэсгээс гаргасан шийдвэрийг үндэслэн албаны дарга, дуудлага худалдааны ялагчтай хөрөнгийн “Эрх шилжүүлэх гэрээ”-г байгуулна.

10.4. Эрх шилжүүлэх гэрээг байгуулахдаа дэнчинг гэрээний үүргийн гүйцэтгэлд оруулж тооцно.

10.5. Хөрөнгийн төлбөр хийгдсэний дараа дуудлага худалдааны ялагч нь татварын албанд хөрөнгийн битүүмжлэлийг цуцлах хүсэлтийг ирүүлэх бөгөөд татварын алба нь уг хүсэлтийг үндэслэн хөрөнгийн битүүмжлэлийг цуцлах тухай шийдвэр гаргаж, битүүмжлэлийг бүртгэсэн байгууллагад хүргүүлэн холбогдох бүртгэлээс хасуулна.

10.6. Татварын алба нь тухайн хөрөнгийн бүртгэлийг хийх эрх бүхий байгууллагад дуудлага худалдааны ялагчийн нэр дээр хөрөнгийн эрхийг шилжүүлэх тухай албан бичиг, эрх шилжүүлэх гэрээ болон холбогдох материалыг албан бичгээр хүргүүлнэ.

10.7. Хөрөнгийн бүртгэлийг хийх эрх бүхий байгууллага нь энэ журмын 10.-д заасан материалыг үндэслэн бүртгэлийг хийнэ.

Арван нэг.Хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулах

11.1.Дараах тохиолдолд хоёр дахь дуудлага худалдааг зохион байгуулна:

11.1.1. дуудлага худалдаанд нэг оролцогч ирсэн;

11.1.2. дуудлага худалдаанд оролцогчид үнийн санал гаргаагүй;

11.1.3. дуудлага худалдааны ялагч дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгийн үнийг энэ журмын 9.6-д заасан хугацаанд бүрэн төлөөгүй бол дуудлага худалдааны үед анхны санал болгосон үнээс илүү санал гаргасан дараагийн этгээдэд санал болгож татгалзсан тохиолдолд;

11.1.4. хоёр дахь дуудлага худалдааг явуулах шийдвэрийг тухайн татварын албаны дарга гаргах бөгөөд хоёр дахь дуудлага худалдааг Иргэний хуулийн 177 дугаар зүйлийн 177.3-т заасан хугацаанд нийтэд мэдээлж, зохион байгуулна.

11.1.5. хоёр дахь дуудлага худалдаанд орж байгаа хөрөнгийн үнийг харилцан тохиролцож тогтоосон, эсхүл үнэлгээчний тогтоосон зах зээлийн үнийн 50 хувиар тооцон тогтооно.

11.1.6.энэ журмын 9.9-т заасан үнэ хаялцуулах дуудлага худалдаагаар борлогдоогүй хөдлөх эд хөрөнгийн үнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4-т заасныг баримтална.

11.1.7.энэ журмын 11.1.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд хоёр дахь дуудлага худалдаанд санал болгох доод үнийг бууруулахгүй.

11.2.Энэ журмын дагуу дуудлага худалдаагаар худалдан борлогдоогүй хөрөнгийг шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлнэ.

Арван хоёр.Дуудлага худалдааны орлого хуваарилах

12.1.Татварын албадан болон үнэ хаялцуулах дуудлага худалдаа болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлсэн орлогыг Татварын ерөнхий хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасныг баримтлан мөн хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу хуваарилна.

Арван гурав.Шууд гэрээгээр хөрөнгийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх

13.1. Шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааг Татварын ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.5-д заасан нөхцөлд татварын албаны даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг энэхүү журамд нийцүүлэн гүйцэтгэнэ.

13.2. Дуудлага худалдаагаар борлуулахад тохиромжгүй буюу галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис, эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлүүд, түлш, шатахуун, мэргэжлийн холбогдох байгууллагын дүгнэлтээр чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан нь тогтоогдсон согтууруулах ундаа, тамхи зэрэг хөрөнгийг шууд гэрээгээр худалдан борлуулна.

13.3. Удаан хадгалахад чанар нь муудах түүхий эдийг уг түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг этгээдтэй шууд гэрээ хийж борлуулж болно.

13.4. Битүүмжилсэн хөрөнгийг бусад хууль, тогтоомжийн дагуу төрийн өмчид давуу эрхээр шилжүүлэн авахаар заасан тохиолдолд холбогдох эрх бүхий этгээдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн шууд гэрээгээр борлуулж болно.

13.5. Шууд гэрээгээр борлуулах хөрөнгийн мэдээллийг ажлын 7 өдрийн өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар нийтэд зарлаж энэ тухайгаа өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ. Хүнсний бүтээгдэхүүнээс бусад түргэн муудаж, гэмтэх хөрөнгийн шууд гэрээгээр борлуулах тухай мэдээллийг тухай бүр нь нийтэд зарлаж, өртэй татвар төлөгчид мэдэгдэнэ.

13.6. Ажлын хэсэг нь шууд гэрээгээр борлуулах хөрөнгийн үнийг энэ журмын 4.1-д заасныг жишиг болгон тогтоож, татварын албаны даргаар батлуулна.

13.7. Хоёр дахь дуудлага худалдаагаар борлогдоогүй хөрөнгийг шууд гэрээгээр худалдан борлуулах тохиолдолд тухайн дуудлага худалдааны үнээс бууруулахгүй.

13.8. Битүүмжилсэн шууд гэрээгээр хөрөнгө борлуулахад 2 ба түүнээс дээш этгээд худалдан авах хүсэлт гаргасан тохиолдолд хүсэлт гаргасан этгээдээс “Үнийн санал авах хуудас”-ыг нууцлалын шаардлага хангуулан бөглүүлэн авч, хамгийн өндөр үнийн санал өгсөн хүнтэй гэрээг байгуулна.

13.9. Хөрөнгийн биржид бүртгэлтэй хөрөнгийг тухайн өдрийн зах зээлийн үнээр борлуулах бүрэн боломжтой тохиолдолд шууд гэрээгээр борлуулж болно.

13.10. Татварын албаны дарга шууд гэрээгээр худалдан авагчтай хөрөнгийг “Худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулна.

13.11. Хөрөнгийг шууд гэрээгээр худалдан борлогдоогүй тохиолдолд татвар төлөгчид хөрөнгийг буцаан олгоно. /Сангийн яамтай зөвших/

13.12. Шууд гэрээгээр худалдан авагч нь гэрээний үнийг 3 хоногт багтаан төлөх бөгөөд төлөөгүй бол татварын алба худалдах шийдвэрийг цуцална.

Арван дөрөв.Маргааныг хянан шийдвэрлэх

14.1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дуудлага худалдаа болон шууд гэрээтэй холбоотой үүссэн маргааныг Татварын ерөнхий хууль, Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу шийдвэрлүүлнэ.



Монголын Татварын Алба

Маягт...

ДУУДЛАГЫН ХУДАЛДААНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТ

1. Дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийг эзэмшигч байгууллагын нэр:
.....
2. Оролцогчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:
3. Оролцогчийн регистрийн дугаар:
.....
4. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:
5. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар:
.....
6. Дэнчингийн хэмжээ: (тоогоор),(үсгээр)
7. Дэнчинг тушаасан: он сар өдөр цаг
8. Оролцогчийн оршин суугаа хаяг:
- Харилцах утас:
9. Хүсэлт бөглөсөн: он сар өдөр цаг
10. Дуудлага худалдааны нөхцөл болон
..... (хөрөнгийн нэр)
- Танилцсан:
- Гарын үсэг:

Жич: Дуудлагын худалдаанд оролцох бүрт энэ хүснэгтийг бөглөж, дэнчинг төлсөн баримтын 1 хувь, оролцогчийн иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргаж, дугуйлж бүртгэлийн хайрцагт хийнэ.

Хүсэлтэд бичигдсэн мэдээллийн үнэн зөв байдлыг оролцогч бүрэн хариуцах ба алдаатай, буруу бөглөсөн бол дуудлагын худалдаанд оролцох боломжгүйг анхаарна уу.





Монголын Татварын Алба

Маягт...

ДУУДЛАГА ХУДАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС

20 ... оны ... дугаар сарын ... өдөр Дугаархот, аймаг

Татварын өр хураах зорилгоор барьцаалсан болон битүүмжилсэн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хууль, Татварын ерөнхий хууль болон бусад эрх зүйн актыг үндэслэн зохион байгуулна.

Дуудлага худалдааны журам:

Оролцогч нь тогтоосон хэмжээгээр дэнчин төлж, дуудлага худалдаанд оролцон үнийн санал гаргах ба дуудлага худалдаанд нэг оролцогч бүртгүүлсэн тохиолдолд дуудлага худалдаа явагдахгүй.

Оролцогч үнийн санал хэлэх эрх олгосон пайзыг өргөн санал гаргах бөгөөд эрхлэн хөтлөгчөөс үнийг гурван удаа давтан хэлж, сүүлийн үнэ зарлан нэгээс гурав хүртэл тоолсноор хамгийн өндөр үнэ санал болгосон оролцогчийг ялагчаар тодруулж, дуудлага худалдааг дуусгавар болгох бөгөөд оролцогч дуудлага худалдааны явцын талаарх тэмдэглэлд гарын үсэг зурна.

Ялагчийн төлсөн дэнчинг худалдан авсан хөрөнгийн үнэд оролцуулан тооцно. Дуудлага худалдаанд оролцогч нь үнийн санал хэлээгүй тохиолдолд дэнчинг буцаан олгохгүй.

Оролцогч үнийг бүрэн төлснөөр дуудлага худалдаагаар борлогдсон эд хөрөнгийг ялагчид хүлээлгэн өгч эрхлэн хөтлөгчийн өмчлөх эрх шилжүүлэх шийдвэрийг холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Дуудлага худалдааны журам зөрчсөн оролцогч дуудлага худалдаанд оролцохгүй, танхимаас гаргана.

Оролцогчийн эрх:

- Сонирхсон мэдээлэлтэй үнэ төлбөргүй танилцах;
- Нийтэд зарласан хугацаанд бүртгүүлж санал өгөх;
- Өөрийн биеэр болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан дуудлагахудалдаанд оролцох;
- Нэгээс илүүгүй зөвлөхийн хамт дуудлага худалдаанд оролцох.

Оролцогчийн үүрэг:

- Анхны болон дахин /үнэ хаялцуулах/ дуудлага худалдаанд оролцогч нь тогтоосон үнийн 10 хувьтай тэнцэх дэнчинг тушаах;
- Дуудлага худалдаанд оролцохоор бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд нэг бүр нь үнийн санал хэлэх;
- Дуудлага худалдааны дуудах үнийн доод үнийг эрхлэн хөтлөгчийн тогтоосон доод хязгаараас өсгөн дуудаж үнийн санал хэлэх;
- Дуудлага худалдаанд ялсан тохиолдолд борлуулсан эд хөрөнгийн үнийг эрхлэн хөтлөгчийн тогтоосон хугацаанд тушаах.

Дуудлага худалдааны явцад утсаар ярих, бичлэг хийх, бусдад саад болохыг хориглоно.

Танилцсан:

Оролцогч:

...../

РД:.....утас

Хаяг:.....





Монголын Татварын Алба

Маягт...

ТУШААЛ /загвар/

Дуудлага худалдаа
явуулах тухай

... оны ... дугаар
сарын...-ны өдөр

Дугаар...

.....
/аймаг, нийслэл/

Татварын ерөнхий хуулийнзаалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татвар төлөгч.....-ний /татвар төлөгчийн нэр, РД, ТТД/ татварын
ерийг хураах зорилгоор 20.. оны ... тоот актаар битүүмжилсэн (барьцааны зүйл), эрхийн
улсын
бүртгэлийн.....дугаартай.....

.....
/үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийн
байршил/

2. үл хөдлөх эд хөрөнгө /агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмж
болон мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас бусад хөдлөх хөрөнгө, биет бус хөрөнгийн аль
хамаарахыг бичнэ/-ийгтөгрөгөөр анхны дуудах үнийг тогтоож,оны.....дугаар
сарын...-ны өдрийн....цаг....минутад.....хаягт байрлах.....татварын газар /хэлтэс/-
аас зохион байгуулах дуудлага худалдаагаар худалдан борлуулсугай.

3.

4.

Гарын үсэг





Монголын Татварын Алба

Маягт...

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

..... татварын газар /хэлтэс/-ын 20... оны ... тоот
тушаалаар (худалдах хөрөнгийн
нэр) дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэв.

1. Дуудлагаар худалдах хөрөнгийн танилцуулга

..... (хөрөнгийн гарал
үүсэл, ашигласан хугацаа, марк, техникийн үзүүлэлт, улсын бүртгэлийн дугаар, төлөв
байдал зэргийг тодорхой тусгана.)

2. Дуудлага худалдааны ерөнхий мэдээлэл

Дуудлага худалдаа болох хугацаа	20..... оны дугаар сарын-ны өдрийн цагт
Дуудлага худалдаа болох газар, хаяг
Худалдах анхны үнэ	Дуудлагаар худалдах хөрөнгийн нэр, Худалдах анхны үнэ (..... үсгээр) төгрөг /хөрөнгийн төрлөөс хамааруулан анхны үнэ зарлах хугацааг харьяалах татварын албаны дарга өөрөөр тогтоож болно/
Дуудлагын худалдаанд тавих дэнчингийн хэмжээ	Худалдах анхны үнийн 10 хувь буюу (..... үсгээр) төгрөг
Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл	Худалдан авагч нь дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгийн үнийг 14 хоногийн дотор төлнө.
Дэнчинг байршуулах данс	Хүлээн авагч байгууллага: Дансны дугаар: Дансны нэр:

3. Дуудлага худалдаанд хүсэлт ирүүлэх

Дуудлага худалдаан оролцох хүсэлтийг 20... оны дугаар сарын-ны өдрийн
..... цаг хүртэл (хаягийг тодорхой тусгана) тоот өрөөнд хүлээн
авна. **Хугацаа хоцорсон хүсэлтийг хүлээн авах боломжгүйг анхаарна уу.**

Дуудлага худалдаанд оролцох хүсэлт нь зөв, цэвэр бөглөсөн худалдаанд оролцох
хүсэлтийн маягт, дэнчин төлснийг нотлох баримт, иргэний үнэмлэх (хуулийн этгээдийн
хувьд улсын бүртгэлийн гэрчилгээ)-ийн хуулбар зэрэг баримтаас бүрдэнэ.

4. Худалдах хөрөнгийн талаар мэдээлэл авах

Дуудлагаар худалдах хөрөнгийг өмч эзэмшигч
байгууллага дээр очиж үзэж болох бөгөөд дуудлагын худалдааны журам, бүртгэх хугацаа,
хөрөнгийн талаарх мэдээллийг татварын газар /хэлтэс/-ын
утсаар болон хаягтай цахим хуудаснаас авна уу.

Хаяг:.....

Холбогдох утасны дугаар:.....





Монголын Татварын Алба

Маягт...

ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ МЭДЭГДЭЛ

20 ... оны ... дугаар сарын ... өдөр Дугаархот, аймаг

Татварын албанаас татварын өрд 20...оны... дугаар сарын ...-ны өдрийн ...дугаар “Хөрөнгө
битүүмжлэх тухай акт”-тай.....татвар
төлөгчийн.....
.....хөрө
нгийг 20... оны... дугаар сарын...-ныөдрийн...цаг...минутанд
..... дуудлага худалдаа зохион байгуулан худалдан
борлуулахаар шийдвэрлэснийг мэдэгдье.

Дуудлага худалдааны зарыг хавсаргав.

Дуудлага худалдаа зохион байгуулах

Ажлын хэсгийн дарга/ /

Мэдэгдлийг 20...оны ... дугаар сарын ...-ны өдрийн ...цаг ... минутад
.....аймаг/хот-ийнсум/дүүрэг,
..... дугаар баг/хороо-ндбайрлахтатвар
төлөгч.....-ийн
ажилтай –нд гардуулав.

Мэдэгдлийг хүлээлгэн өгсөн ТУБ:.....

Мэдэгдлийг хүлээн авсан:.....





Монголын Татварын Алба

Маягт...

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

20 ... оны ... дугаар сарын ... өдөр Дугаархот, аймаг

1. Харьяалах татварын албаны нэр:
 2. Дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн нэр, марк, дугаар, тоо хэмжээ:
.....
 3. Дуудлага худалдааны зар гаргасан сонины нэр, дугаар, он, сар, өдөр:
.....
 4. Дуудлагын худалдаа явагдсан газар, он, сар, өдөр, цаг, минут:
.....
 5. Дуудлага худалдааны анхны үнэ:
(.....) төгрөг
 6. Дэнчингийн хэмжээ:
(.....) төгрөг
 7. Дуудлага худалдаанд оролцогчийн нэр:
Оролцогчийн нэр Пайзны дугаар
1.
2.
3.
4.
5.
 8. Ажиглагчийн нэр:
1.
2.
3.
 9. Нэмэлт тэмдэглэл:
 10. Дуудлагын худалдааг зохион байгуулж явуулсан:
1. татварын газар /хэлтэс/-ын төлөөлөгч:.....
2. Хөтлөгч:
3. Тэмдэглэл хөтлөгч:
- Хөтлөгч дуудлагын худалдааны журмыг танилцуулж, дуудлагын худалдаа эхэлснийг зарлав. Өсгөн нэмэгдүүлэх үнийн доод хязгаар (.....) төгрөг, дээд хязгаар (.....) төгрөг болохыг танилцуулав.



Дуудлагын худалдаа дараах байдалтай явагдав.

№	Пайзны дугаар	Үнийн санал	№	Пайзны дугаар	Үнийн санал	№	Пайзны дугаар	Үнийн санал

Дуудлага худалдааны эцсийн үнэ: төгрөг мөнгө(..... үсгээр)

Удаах оролцогчийн эцсийн үнийн санал: төгрөг мөнгө(..... үсгээр)

Дуудлагын худалдааны ялагчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:

Оршин суугаа хаяг, харилцах утас:.....

Удаах оролцогчийн эцэг/эх/-ийн нэр, нэр:

Оршин суугаа хаяг, харилцах утас:.....

Дуудлагын худалдааны тэмдэглэлтэй танилцсан: татварын газар /хэлтэс/-ын төлөөлөгч:

Дуудлагын худалдааны хөтлөгч:

Дуудлагын худалдааны тэмдэглэл хөтлөгч:

Дуудлагын худалдаанд оролцогч:

1.
2.
3.
4.
5. /оролцогчийн нэр, гарын үсэг/





Монголын Татварын Алба

Маягт...

ТУШААЛ /загвар/

Хоёр дахь дуудлага худалдаа
явуулах тухай

... оны ... дугаар
сарын...-ны өдөр

Дугаар...

.....
/аймаг, нийслэл/

ТЕХ-ийн –г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татвар төлөгч.....-ний/татвар төлөгчийн нэр, РД, ТТД/татварын өрийг хураах зорилгоор 20... оны ... тоот актаар битүүмжилсэн(барьцааны зүйл), эрхийн улсынбүртгэлийн.....дугаартай.....

.....
/үл хөдлөх эд хөрөнгө, агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмжийн байршил/хаягт байрлах үл хөдлөх эд хөрөнгө /агаарын хөлөг, автомашин, барилгын тоног төхөөрөмж болон мөнгөн хөрөнгө, үнэт цааснаас бусад хөдлөх хөрөнгө, биет бус хөрөнгийн аль хамаарахыг бичнэ/ нь 20... оны ... дугаар сарын ...-ны өдөр зохион байгуулсан дуудлага худалдаагаар/үндэслэлээр/ борлогдоогүй байх тул анхны дуудлага худалдааг хүчингүйд тооцсугай.

2. Дуудлага худалдаагаар борлогдоогүй хөрөнгийн анхны үнэ.....төгрөгийг 20 хувь бууруулжоны.....дугаар сарын...-ны өдрийн.....цаг.....минутад.....хаягт байрлах.....татварын газар /хэлтэс/-аас зохион байгуулах 2 дахь дуудлага худалдаагаар худалдан борлуулсугай.

3.

4.

Гарын үсэг





Монголын Татварын Алба

Маягт...

ҮНИЙН САНАЛ АВАХ ХУУДАС

20 ... оны ... дугаар сарын ... өдөр Дугаархот, аймаг

Татварын албаны нэр:.....

Хөрөнгийн нэр:.....

Тоо ширхэг:.....

Нэг бүрийн

үнэ:.....

Бүгд үнэ:.....

Шууд гэрээгээр худалдах худалдаанд оролцогчийн

нэр:.....

Регистр:.....

Хаяг:.....

.....

.....

Хөрөнгөнд өгөх үнийн санал:.....

(..... үсгээр)

Оролцогчийн гарын үсэг:.....





Монголын Татварын Алба

Маягт...

ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

20 ... оны ... дугаар сарын ... өдөр Дугаархот, аймаг

Энэхүү гэрээг нэг талаас татварын газар /хэлтэс/ (цаашид "худалдагч" гэх), нөгөө талаас татварын газар /хэлтэс/-ийн тоот өрөөнд явагдсан шууд гэрээгээр худалдан авагч болсон иргэн /эсхүл хуулийн этгээд гэх/ (цаашид "худалдан авагч", хамтад нь "талууд" гэх) нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож Иргэний хуулийн 197 дугаар зүйлийн 197.2 дахь хэсэг, 243-261 дүгээр зүйл, Татварын ерөнхий хуулийн 68 дугаар зүйл /холбогдох бусад хууль тогтоомжийг нэмэх/-ийг үндэслэн байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэрээний зорилго: Худалдагч гэрээнд заасан эрхийн зөрчилгүй /хөрөнгийн марк, төрөл зэрэг мэдээллийг тусгах/ (цаашид "хөрөнгө" гэх)-ыг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх журам, гэрээнд дурдсан нөхцөлөөр үнийг төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.

1.2. Гэрээний зүйл: Худалдах, худалдан авах хөрөнгө нь хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй улсад онд үйлдвэрлэсэн /нийт жил ашигласан/, "....." маркийн, өнгөтэй, /техникийн болон шаардлагатай үзүүлэлтийг нэмэх/ байна. /шаардлагатай бол гэрээний зүйлийн тодорхойлолтыг хавсралтад тусгах/

1.3. Энэ гэрээ нь албан ёсоор байгуулагдсан өдрөөс эхлэн гэрээгээр хүлээсэн үүрэг бүрэн биелэх хүртэл хугацаанд үйлчилнэ.

Хоёр. Хөрөнгө шилжүүлэх

2.1. Худалдан авагч хөрөнгийн төлбөрийг гэрээнд заасны дагуу бүрэн төлснөөр өмчлөх эрхтэй болно.

2.2. Худалдагч хөрөнгө, түүнтэй холбоотой бичиг баримтыг төлбөр бүрэн төлөгдсөнөөс хойш ажлын 5 өдрийн дотор 2 хувь акт үйлдэж шилжүүлнэ.

2.3. Гэрээний зүйл нь эрхийн зөрчилгүй байна. Эрхийн зөрчилгүй гэдэгт гуравдагч этгээд өөрийн эдлэх эрхийн талаар ямарваа нэгэн гомдлын шаардлага гаргахгүй байхыг ойлгоно.

2.4. хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэхтэй холбогдон гарах үйлчилгээний хураамж болон бусад зардлыг худалдан авагч хариуцна.

2.5. хөрөнгийг худалдан авагчид хүлээлгэн өгөхөөс өмнөх хугацааны татвар, хураамж, даатгалтай холбоотой зардлыг худалдагч бүрэн хариуцна.

Гурав. Төлбөр тооцоо

3.1. Энэхүү гэрээний 1.2-т заасан хөрөнгийн нийт үнэ (.....) /тоогоор, үсгээр хамт бичих/ төгрөг болно. Энэ нь эцсийн үнэ байна.

3.2. Хөрөнгийн зах зээлийн үнэ, валютын ханш өөрчлөгдөх нь энэхүү гэрээний 3.1-д заасан үнийг өөрчлөх үндэслэл болохгүй.



3.3. Худалдан авагч нь дэнчин болгон нийт (.....) /тоогоор, үсгээр хамт бичих/ төгрөгийн тушаасан бөгөөд дэнчин нь энэхүү гэрээний 3.4-д заасан үнэд тооцогдоно.

3.5. Худалдан авагч нь гэрээ албан ёсоор байгуулагдсанаас хойш ажлын 3 хоногийн дотор үлдэгдэл төлбөр болгох (.....) /тоогоор, үсгээр хамт бичих/ төгрөгийг худалдагчийн, дансны нэр ".....", тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг

4.1. Худалдагчийн эрх, үүрэг:

4.1.1. Худалдагч нь худалдан авагчид эрхийн доголдолгүй хөрөнгийг гэрээнд заасны дагуу хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.1.2. Хөрөнгийн үнийг гэрээнд заасан хугацаанд төлөхийг худалдан авагчаас шаардах эрхтэй.

4.1.3. Худалдан авагч хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг улсын орлогод авч, гэрээг дангаар цуцлах эрхтэй.

4.1.4. Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

4.2. Худалдан авагчийн эрх, үүрэг:

4.2.1. Гэрээнд заасны дагуу эрхийн доголдолгүй хөрөнгийг актаар хүлээн авах эрхтэй.

4.2.2. Хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.

4.2.3. Худалдан авсан хөрөнгийн үнийг бүрэн төлснөөр хөрөнгө, өмчлөх эрхийг шилжүүлэх авах болон холбогдох баримтыг шаардах эрхтэй.

4.2.4. Хөрөнгийг хүлээлцэхээр тогтоосон хугацаанд хүлээн аваагүй тохиолдолд тухайн хөрөнгийг хадгалах, хамгаалах, арчлахтай холбогдон гарах зардлыг нөхөн төлөх үүрэгтэй.

4.2.5. Гэрээний үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй.

Тав. Талуудын хариуцлага

5.1. Энэ гэрээний нөхцөлийг зөрчсөн буруутай тал түүнээс болж нөгөө талд учирсан бүх хохирол, алдагдлыг үл маргалдах журмаар төлнө.

5.2. Худалдан авагч хөрөнгийн үнийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол худалдаж авах эрхээ алдана.

5.3. Худалдан авагч хөрөнгийн үлдэгдэл төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй бол дэнчинг нэхэмжлэх эрхээ алдах ба энэхүү гэрээг худалдагчийн санаачилгаар цуцлах үндэслэл болно.

5.4. Худалдан авагч нь тогтоосон хугацаанд хөрөнгийг хүлээн аваагүй тохиолдолд хөрөнгө хүлээлцэхээр тогтоосон өдрөөс хойшхи гэмтэл, доголдлыг худалдагч хариуцахгүй болно.

Зургаа. Маргааны шийдвэрлэх

6.1. Талууд энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

6.2. Хэрэв харилцан тохиролцох боломжгүй бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйл

7.1. Талууд гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйлийн улмаас үүссэн эрсдэлийг бие даан хариуцах бөгөөд үүнтэй холбоотой аливаа асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

7.2. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйл (үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлт, террорист үйлдэл, иргэдийн үймээн, бослого, нийтийн эмх замбараагүй байдал)-ийн улмаас биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөлийг арилах хүртэл хойшлуулж болно.



7.3. Энэхүү гэрээний үүргийн биелэлтэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нөгөө талдаа яаралтай мэдэгдэнэ.

7.4. Шаардлагатай бол төрийн эрх бүхий байгууллагын баримт нь гэнэтийн болон давтагдашгүй хүчин зүйл мөн байсан болон түүний үргэлжилсэн хугацааны нотолгоо болно.

Найм. Бусад нөхцөл

8.1. Энэ гэрээ нь хавсралтын хамт нийт (.....) хуудас, үндсэн эхийг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр 1 хувийг хадгална. Гэрээний эх хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.2. Талууд энэ гэрээнд дурдаагүй бусад асуудлыг шийдвэрлэхэд Иргэний хууль тогтоомжийг удирдлага болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

..... татварын газар /хэлтэс/-ын
/нэр, албан тушаал/

Хаяг:

Утас:

И-мэйл хаяг:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Иргэн
/эсхүл хуулийн этгээд/

Хаяг:

Утас:

И-мэйл хаяг :





Монголын Татварын Алба

Маягт...

ХУВААРИЛАЛТЫН ТООЦООНЫ АКТ

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

Дугаар ...

..... хот, аймаг

Татварын албаны дарга /тамга/			
Доор заасны дагуу битүүмжилсэн хөрөнгийн борлуулалтын орлогыг хуваарилна. Татварын ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн дагуу энэ тооцооны хуудсыг үйлдэв.			
Өртэй татвар төлөгч	Хаяг		
	Нэр		
Дуудлага худалдаагаар болон шууд гэрээгээр хөрөнгийг борлуулсанаас орсон орлого	Мөнгөн хэлбэртшилжүүлсэн эд хөрөнгийн нэр, тоо хэмжээ, шинж чанар болон байршил	Мөнгөн дүн	
	Нийт дүн /А /		
Дуудлага худалдаагаар болон шууд гэрээгээр хөрөнгийг борлуулахтай холбогдон гарсан зардал	Зардлын төрөл	Дүн	Хавсаргасан баримт
	Хөрөнгө хүлээн авах болон дуудлага худалдааг зохион байгуулахтай холбогдон гарсан зардал		
	Хадгалалт тээвэрлэлттэй холбогдон гарсан зардал		
	Дээд шатны татварын албаны төлөөлөгч ажиллуулахтай холбогдон гарсан зардал		
	Хөрөнгийн анхны үнэ тогтооход мэргэжлийн байгууллага болон мэргэжилтний туслалцаа авсан бол түүний үйлчилгээний хөлс		
	Нийт дүн /Б /		
Үлдэгдэл дүн / А-Б /			
Татварт суутгах дүн			
Илүү, дутуу (-)	Татварын албанд		
	Татвар төлөгчид		

Тооцоог үйлдсэн

Татварын албаны Ажлын

Өртэй татвар төлөгчийн

хэсгийн ахлагч...../

/ Нэр...../

/





Монголын Татварын Алба

Маягт...

ХУДАЛДАН БОРЛОГДООГҮЙ ЭД ХӨРӨНГИЙГ ТАТВАР ТӨЛӨГЧИД БУЦААХ ТУХАЙ

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

Дугаар ...

.....хот, аймаг

..... татварын газар /хэлтэс/-ийн даргын 20 ... оны ... сарын ... өдрийн тоот
“Дуудлага худалдаанд худалдан борлогдоогүй эд хөрөнгийг татвар төлөгчид буцаах
тухай” тушаалыг үндэслэн

1. Татвар төлөгч -ны өмчлөл / эзэмшил/-ийн.....
дугаарт бүртгэлтэй хаягт байрлах
дуудлага худалдаагаар худалдан
борлогдоогүй..... эд хөрөнгийг татвар төлөгч
.....-нд хүлээлгэн өгөв.

2. Санал Битүүмжилсэн барьцаалсан дугаар тоот..... бас улсын бүртгэлд
хүргүүлэх шаардлагатай эсэх

Хүлээлгэн өгсөн:

Татварын албаны Ажлын

хэсгийн ахлагч...../

Ажлын хэсгийн гишүүд

.....

Хүлээн авсан:

Татвар татвар төлөгчийн / төлөөлж /

/ Нэр...../ /

Төлөөлж





Монголын Татварын Алба

Маягт...

ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ДЭНЧИНГ ТӨСВИЙН ОРЛОГО БОЛГОХ ТУХАЙ

..... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар...

.....
/аймаг, нийслэл/

..... газар/ хэлтэс/-ын 20 оны сарын өдөр зохион байгуулсан дуудлага худалдааг хянахад төгрөгийн үнийн саналаар үл хөдлөх худалдан авсан ялагч нь дуудлага худалдааны эрхлэн хөтлөгчийн шийдвэрт заасан хугацаанд эд хөрөнгийн үнийг төлөөгүй байх тул Татварын Ерөнхий хуулийн үндэслэн:

1. 20 оны дугаар сарын -ны өдрийн дуудлага худалдааны ялагч -ны тушаасан дэнчин төгрөг мөнгийг улсын орлого болгосугай.

Гарын үсэг





Монголын Татварын Алба

Маягт...

АВЛАГЫН ХҮСЭЛТ

..... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар...

.....
/аймаг, нийслэл/

..... регистрийн дугаартай ХХК нь 20 оны сарын
өдрийн тоот шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж, гэрээний дагуу үүссэн
..... төгрөг / бичгээр бичих / өрийг суутган авч / иргэн, ХХК / тоот
дансанд ТЕРХ-ийн 69 дүгээр зүйлд заасны дагуу шилжүүлж өгнө үү.

..... ХХК-ийн битүүмжилсэн, барьцаалсан, дуудлага худалдааны
орлогоос тоот гэрээ болон шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамжийн дагуу
өрийг бүрэн суутган шилжүүлэх боломжтой эсэх талаар хариу мэдэгдэж тусална уу.

Хүсэлт гаргасан:

Хүсэлтэд хавсаргах материал

1. Албан бичиг, өргөдөл
2. Татвар төлөгчөөс авах авлагыг нотлох баримт / Шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэр, гэрээгээр ажил гүйцэтгэсэн бол тооцоо нийлсэн акт, ажил гүйцэтгэсэн гэрээ, ажил хүлээлцсэн акт
3. Бусад нотлох баримт

